

**МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН
2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН
ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 10 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа

Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2024 оны 10 дугаар сарын 04,18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон холбогдох бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд тус тус шилжүүлсэн.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан журмын дагуу дээрх хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат 2025 оны төсвийн төсөлд тусгагдсан төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдлийг 6 хувиас дээш нэмэгдүүлэх боломжтой эсэх, эрүүл мэндийн даатгалын сангийн техникийн хорооны үйл ажиллагааны зардлын төсвийг тусгах асуудал, эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэлд хүү тооцохгүй байгаа талаар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох төсвийг тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа ядуурлыг бууруулах хүрээнд халамжаас хөдөлмөрт шилжихэд төгсөлтийн аргачлалыг хэрхэн чиглүүлсэн, Хүүхдийн төлөө санд 2024 онд тусгагдсан төсвийн зарцуулалт болон 2025 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар, жороор олгох эмийн жагсаалтыг хэрхэн шинэчлэх, цахим жор болон эрүүл мэндийн салбарын цахимжилтийн явцын талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун “Элэг бүтэн Монгол”, “Эрүүл Монгол хүн”, “Эрүүл шүд” хөтөлбөрийн зардлын бүтэц, эрт илрүүлэг болон хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээнд тусгагдсан төсвийн талаар, дохионы хэлний “duudlaga.mn” цахим хуудас хорин дөрвөн цагаар ажиллаж эхэлсэн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа Нийгмийн даатгалын сангийн өр, авлагын асуудлыг хэрхэн шийдвэрлэх, цаашид алдагдалгүй ажиллахад хэрхэн анхаарч ажиллах, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хорооны ажлыг сайжруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Эрүүл мэндийн даатгалын санд үүссэн өглөгийг барагдуулахад шаардагдах төсөв 2025 оны төсөвт тусгагдсан эсэх, нийслэлээс алслагдсан хэдэн аймгийн төв оношилгооны тоног төхөөрөмжийн дутагдалтай, тэдгээрийн хэдийг 2025 онд шийдвэрлэж байгаа талаар, иргэний эрүүл мэндээ хамгаалах үүргийг хэрхэн сайжруулах болон тэтгэврийн даатгалын санд

алдагдал үүссэн шалтгаан, орон нутагт хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдэд хийгдэж буй аудитын талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара Эрүүл мэндийн сайдын төсөвт багтах тоног төхөөрөмж худалдан авах төсвийн задаргааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага барагдуулах ажлын явц, 2025 оны Улсын төсвийн нэгдүгээр хавсралтад тусгагдсан хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг ямар аргачлалаар боловсруулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат орон нутгийн эмч, бага эмч нарыг гадаад улсад сургалтад хамруулах, туршлага судлуулахад хэрхэн анхаарч байгаа, ажиллах хүчний хомсдол үүсэж байгаатай холбогдуулан гаднаас ажиллах хүч оруулж ирэхэд тавигдах шаардлагыг уян хатан зохицуулахад чиглэсэн бодлого, Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг зөвхөн хүүхдэд зориулахад хэрхэн анхаарч байгаа талаар, Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан холбогдох төсвийг тусгасан эсэх талаар Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй 2 саналын томъёоллыг урьдчилан ирүүлсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.6 дахь хэсэгт заасны дагуу санал тус бүрээр санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томъёолж, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 төсвийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ**



М.ГАНХҮЛЭГ

2024.10.24

**МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН
2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН
ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ГИШҮҮДЭЭС ГАРГАСАН
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

1. 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцын урсгал зардалд багтах Нийгмийн халамжийн сангийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний санхүүжилтэд тусгагдсан 21,381.2 сая төгрөгийг 300.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардлын өмгөөлөл хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс зориулалтад нэмж тусгах

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа

Хоёр.Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал:

1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2-р хавсралтын бүх төсөл арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 5 хувиар бууруулж, Эрүүл мэндийн сайдын багцын урсгал зардлыг 205.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа

..... ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН
ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛЛЫН ХУУДАС

2025.10.28. 15:32.7
ӨНӨН /

Д/д	Зүйл, хэсэг, заалтын дугаар	Нэг.Зохицуулалт хийх санал				Хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх	Төсвийн төслийн зарлагын болон алдагдлын дүнг нэмэгдүүлээгүй эсэх	Төсвийн тухай хуулийн 6.2.6, 29.3, 29.4-т нийцсэн эсэх
		Зардал бууруулах төсөл, хөтөлбөр, арга хэмжээ	Нэр	Буурах дүн	Нэр			
1	МОНГОЛ Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт	Бүх төсөл арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 5 хувиар бууруулах	Нэр	Буурах дүн	Нэр	Нэмэгдэх дүн	Нийцнэ	Нийцнэ
					Эрүүл мэндийн сайдын багцын урсгал зардлыг 205 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх Эмч нарын цалин урамшуулал, эмнэлгийн хангамжийн зардлыг нэмэгдүүлэх замаар тусламж, үйлчилгээг найдвартай үзүүлэх	205 тэрбум төгрөг	Нийцнэ	Нэмэгдүүлэхгүй буюу улсын төсвийг дахин хуваарилах зарчмаар
2		Хоёр.Төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэр өөрчлөх санал						
		Төсөлд тусгагдсан нэр				Өөрчлөх нэр		

Гарын үсэг:  /санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн, Д.Ганмаал

Санал хураалгасан сар, өдөр, цаг:
..... 2025.10.28. 15:32.7

317.

УИХ-ын гишүүн Д. Чиршигтүвшин-ны
зарчмын зөрөөтэй саналын томъёоллын хуудас

Саналыг төслийн ямар зүйл, хэсэг,
заалтын талаар гаргаж байгаа

2025 оны төсвийн тухай хуулийн төслийн
6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг

Санал гаргасан сар, өдөр, цаг

2024.10.22, 11 цаг


Санал хураалгах болсон үндэслэл

Нийгмийн даатгалын санд үүссэн өр төлбөр, эрсдэлтэй авлагыг барагдуулах зорилгоор хууль эрх зүйн зөвлөгөө авах хууль, эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, мэргэжлийн хуулийн фирмтэй гэрээ байгуулах

Саналын томъёолол

2025 оны төсвийн тухай хуулийн төслийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцын урсгал зардалд багтах нийгмийн халамжийн сангийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ зориулалтын "21,381,155.3" мян.төгрөгийг 300 сая төгрөгөөр бууруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны зардлын өмгөөлөл хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс зориулалт дээр 300.0 сая.төгрөгийг нэмэх.

ГАРЫН ҮСЭГ /санал гаргасан УИХ-ын
гишүүн нам эвслийн бүлэг/



Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг

2024.10.22, 11 цаг

Санал хураасан сар, өдөр, цаг

2024.10.24

Зөвшөөрсөн /Тоо, хувь/

56.2%